



ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Хурал 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул Дүүрэг, 15-р хороо, Гандигийн гудамж, NM tower оффис, 8 давхар хурлын танхимд <https://aqm.mn/> цахим хурлын системээр зохион байгуулагдав болов.

Хурлын дарга:

Адилбишийн Баттамир.

Хурлын ирц:

Инновэйшн инвестмент ХК-ийн саналын эрхтэй нийт 171,397,098 ширхэг хувьцаанаас 77.58 хувь буюу 132,975,828 ширхэг хувьцаа эзэмшиж буй 35 хувьцаа эзэмшигч хуралд оролцон.

Хэлэлцэх асуудал:

№	ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛУУД	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Санал
1.	Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай	Тогтоол №1				
2.	ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг батлах, нөхөж олгох тухай	Тогтоол №2				
3.	Компанийн шинэчилсэн дүрэм батлах тухай	Тогтоол №3				

Хэлэлцсэн нь:

Тооллогын комиссын дарга Г.Энхжин:

Хурлын ирцийг бүртгэж хурлын ирц хүчин төгөлдөр болохыг танилцуулав.

Хурлын дарга А.Баттамир:

Нийт хувьцаа эзэмшигчидэд мэндийг дамжуулж хурлын ирц бүрдсэн тул хурлыг эхлүүлэв.

2024 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны ерөнхий мэдээллийг хувьцаа эзэмшигч нарт хүргэв. Үүнд:

1. ТУЗ-ийн бүрэлдэхүүн ердийн 6, хараат бус 3 гишүүнтэй үйл ажиллагаагаа явуулсан.
2. ТУЗ нийтдээ 4 хороонд хуваагдаж 22 тогтоол шийдвэр гаргаж ажилсан.

ХЭЭХ-ын хэлэлцэх асуудал болон дэгийг танилцуулав.

Гүйцэтгэх захирал Г.Эрдэнэмөнх:

Хурлаар хэлэлцэх асуудлуудыг дэлгэрэнгүй танилцуулав.

Хурлын дарга А.Баттамир:

Хурлаар хэлэлцэх асуудлууд тус бүр дээр тогтоолын төслүүдийг дэлгэрэнгүй танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдээс асуултуудыг хүлээн авав.

Гүйцэтгэх захирал Г.Эрдэнэмөнх:

1-р асуулт: Apple pay зэрэг NFC зэрэг NFC шийдлүүдийн өрсөлдөөнд авах цаашдын арга хэмжээ юу вэ?

Хариулт: Бид 2025 оны 5-р сараас Apple pay-ийн борлуулалтыг хийж эхэлнэ. Манай компаниар дамжуулж Apple pay-ийн мерчант болоорой гэдэг ажил явагдана. Үүнд онлайн, апп суурьтай мөн кассын системээр дамжуулж төлбөр төлөх боломжийг нь олгоно. Мөн 2025 оны 2-р улиралд ашиглалтанд орох мерчант апп дээр NFC-ийн төлбөр тооцоонууд хийх android системтэй утас хэрэглэгчдэд нээгдэнэ. Мөн Paypal-аар дамжуулж гаднаас төлбөр тооцоо хүлээн авах боломжийг нэвтрүүлнэ.

2-р асуулт: QPay үйлчилгээний олон улсын төлбөр тооцооны тухай.

Хариулт: Бид union pay, we chat, Солонгосын gla мөн дотоодод paypal, apple pay нэвтрүүлж байгаа компаниудтай хамтарч ажиллаж байна. 2025 оны хувьд төв Азийн зах зээл дээрх төлбөр тооцооны шийдлүүдийг Монгол улсад нэвтрүүлэх оны сүүлээр зүүн өмнөд Азийн төлбөр тооцооны системүүд дээр ажиллаж Монголчууд аялаж, зуугаалахдаа Qpay-р дамжуулан төлбөр тооцоогоо хийх боломжуудыг нэвтрүүлээд явна.

3-р асуулт: Татварын өглөг өссөн байна.

Хариулт: Дансны өглөгийн өсөлт нь үйл ажиллагаатай холбоотой байгууллагуудад дараа сардаа тооцоогоо нийлгэхтэй холбоотой үүссэн. Татварын өрийн өсөлт нь үйл ажиллагаа өргөжөөд борлуулалтын орлого нэмэгдсэнтэй холбоотой. Ногдол ашгийн өглөг нь 2024 оны ногдол ашиг санхүүгийн тайланд богино хугацаат өр төлбөрөөр бүртгэгдэж байгаад ТУЗ-ийн шийдвэр гарсны дараа олгогдоно.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын санал хураалт болон санал тоолох ажил.

Тооллогын комиссын дарга Г.Энхжин:

Санал хураалтын дүнг танилцуулав.

Хурлын дарга А.Баттамир:

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын батлагдсан тогтоолыг уншиж танилцуулан хэвэлмэл тогтоол дээр гарын үсэг зурж хурлыг хаав.

Шийдвэрлэсэн нь:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн **99.3** хувь буюу **132,046,674** ширхэг хувьцаа эзэмшиж буй **28** хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн **99.99** хувь зөвшөөрсөн, **0** хувь татгалзсан, **0.000002** хувь түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
132,046,672	99.99%	0	0%	2	0.000002%

2. ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг батлах, нөхөж олгох тухай тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн **99.3** хувь буюу **132,046,674** ширхэг хувьцаа эзэмшиж буй **28** хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн **95.37** хувь зөвшөөрсөн, **0** хувь татгалзсан, **4.62** хувь түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
125,942,750	95.37%	0	0%	6,103,924	4.62%

3. Компанийн шинэчилсэн дүрэм батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн **99.3** хувь буюу **132,046,674** ширхэг хувьцаа эзэмшиж буй **28** хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн **99.99** хувь зөвшөөрсөн, **0** хувь татгалзсан, **0.000002%** хувь түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
132,046,672	99.99%	0	0%	2	0.000002%

тус тус санал авч эдгээр асуудлуудыг шийдвэрлэв.

Хурлын дарга:



А.БАТТАМИР

Тэмдэглэл хөтөлсөн:

Л.ЗОЛБАЯР /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/